

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - ДЭЭД БОЛОВСРОЛ” СЭДЭВТ БАГШ НАРЫН II ЗӨВЛӨГӨӨНИЙ “СУДАЛГАА, ИННОВАЦИ” САЛБАР ХУРАЛДААНЫ ЗӨВЛӨМЖ

ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГАД:

- МУ-ын төрийн өмчийн их сургуулиудын хөгжлийн Альянс хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж сүлжээ лаборатори байгуулж, судлаачдын нийгэмлэг үүсгэснээр судалгааны нөөцийг төвлөрүүлэн, үр ашгийг нэмэгдүүлэх, технологийн нэгдсэн мэдээллийн сан, менежменттэй болон технологи дамжууллыг альянс хэлбэрээр гүйцэтгэснээр их сургуулиуд, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх
- Судалгааны лабораторийн ашиглалтыг сайжруулах, ажиллах хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, лабораториудын үйл ажиллагааны уялдаа, зохион байгуулалтын зөв менежментийг явуулах, материаллаг бааз, урвалж бодисын ханган нийлүүлэх тогтолцооны менежментийг сайжруулах; урсгал зардлыг сургуулийн төсөвт суулгадаг болох

ЗАСГИЙН ГАЗАРТ:

- Их сургуулиуд Альянс хөтөлбөр хэрэгжүүлж нөөцийг үр ашигтай ашиглаж, оновчтой нэгдсэн менежментээр зохион байгуулахыг эрх зүйн орчин болон санхүүжилтээр дэмжих, дараах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
 - “Судалгааны сүлжээ лаборатори” дэд хөтөлбөр
 - “Mongolian Science Citation Indexed Journals” дэд хөтөлбөр
 - “Профессор, судлаачдыг дэмжих” дэд хөтөлбөр
- Судалгааны их сургуулийн шалгуур, босго үзүүлэлтийг тогтоож, тэргүүлэх сургуулиудыг дэмжих, бусад сургуулийн босго давахад чиглэсэн хөтөлбөрийг дэмжих өрсөлдөөнт тэтгэлгийг хэрэгжүүлэх
- Улс орны өмнө тулгарч буй цогц асуудал шийдвэрлэх олон салбар дундын судалгааг захиалж санхүүжүүлдэг болох (Жишээ нь нэг хотын шийдэл, нэг сумын шийдэл, утаа г,м)
- Судалгааны төвлөрсөн санхүүжилтийг зохицуулах бодлогын бичиг баримтыг тодорхой болгох
- Судалгааны санхүүжилтийн хэмжээг дорвитой нэмэгдүүлж, судалгааг хангалттай хэмжээгээр тасралтгүй дэмждэг тогтолцоотой болох, захиалгат судалгааны төслийг сүлжээ лаборатори, салбар дундын жишиг лабораторийг түшиглэн хэрэгжүүлдэг болох
- Шилдэг эрдэмтэн судлаач, суралцагчдын төвлөрлийг бий болгох зорилгоор магистр, доктор, докторын дараах сургалтын тэтгэлгийн сантай болох

- Монгол улсын Технологийн форсайт (foresight) болон форкастинг (forecasting)-ийн судалгааг цаг алдахгүй гүйцэтгэж, Монгол улсын аж үйлдвэрийн салбарт дорвитой хувь нэмэр оруулах, ялангуяа дэлхий зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэхэд шаардагдах тэргүүлэх технологиудыг тодорхойлж, энэ чиглэлдээ Технологийн кластер, парк байгуулах ажлыг дэмжих шаардлагатай байна
- Тэргүүлэх чиглэлээр судалгааны сэдвээ захиалан олон улсын тэргүүлэх их сургуулиудад магистрант, докторант сургаж судлаачдын критик масс үүсгэх. Судалгааны тодорхой сэдвүүдийг дэмжиж буй Монгол-Японы “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн загвар, туршлагаар Герман, АНУ зэрэг технологиор тэргүүлэгч улсуудтай төстэй төсөл хэрэгжүүлэх
- Салбар дундын (ШУА-Их сургууль-Хүрээлэн, төв-Бизнесийн байгууллагууд) сургалт, судалгааг дэмжих санхүүгийн механизм, судалгааны нээлттэй лаборатори, төвийн хамтын ажиллагааны уялдаа холбоог хангаж ашиглах, хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох
- БСШУСЯ-аас магистр докторын сургалтын чанарыг сайжруулах, үйл ажиллагааг оновчтой болгохын тулд тулгамдаж буй асуудал, бэрхшээлүүдийг шийдвэрлэх талаар холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулан их сургуулиудыг нэгдсэн бодлогоор ханган Ахисан түвшний сургуулийг байгуулах
- Сүлжээ лаборатори болон салбар дундын нэгдсэн жишиг лабораторийг нэрлэн, тоног төхөөрөмжийн арчилгааны, ашиглалтын зэрэг урсгал зардлыг шийдвэрлэх;
- Монголын улсын хэмжээнд оюуны өмчийн хөрөнгийн үнэлгээ хийх улсын стандартыг боловсруулж, батлуулах
- Улсын хэмжээний судалгааны тоног төхөөрөмжийг хангамж, худалдан авалтыг хариуцсан комисстой болох

УЛСЫН ИХ ХУРАЛД:

- Их сургуулийн засаглалын бие даасан байдлыг хуульчлах
- Боловсролын тухай хууль болон дээд боловсролын тухай хуульд дээд боловсролын сургалтын байгууллагын ангилалд “Сургалтын их сургууль”-ийг нэмж оруулах, сургалтын их сургуульд тавигдах шаардлага, шалгуур, босго үзүүлэлтийг тусгах
- “Судалгааны их сургууль” үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх
- Монгол улсын Технологийн форсайт (foresight) болон форкастинг (forecasting)-ийн судалгааг тогтмол гүйцэтгэдэг байнгын зөвлөлийг Шинжлэх

Ухаан Технологийн Үндэсний Зөвлөлийн доор байгуулж, хараат бус ажиллах нөхцөлийг хуульчлах

- Төрөөс шинжлэх ухаан, технологид зарцуулах санхүүжилтийг жил бүр тодорхой хувиар нэмдэг болохыг хуульчлах
- Технологи, инженерийн ухаан хөгжих суурь болсон Байгалийн ухааны сургалт болон суурь судалгааны зардлыг төрөөс бүрэн даадаг болох.
- Судалгааны тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг нийтлэг хэрэглэгддэг гадаадын үйлдвэрлэгчээс шууд худалдан авах боломжийг төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжид нэмж оруулах;